



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД
ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ,
ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ”

АУДИТЫН КОД: ГАА-2025/92-ШТА-НА

Говь-Алтай аймаг 2025 он



Дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа

Утас: 70483413 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Аудитор Ц.Сайханжаргал

Утас: 70484030 Цахим хаяг: saikhanjargalts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

1. Товчилсон үгийн жагсаалт.....	2
2. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	3
3. Аудитын зорилт.....	3
4. Аудитын хамрах хүрээ.....	3
5. Аудитад ашигласан арга зүй, шалгуур үзүүлэлт.....	3
6. Аудитын бүрэлдэхүүн, хугацаа.....	3
7. Үндсэн мэдээлэл.....	4
8. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 3 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа хувийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлээгүй байна.	5
9. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 2 нам сонгуулийн зардлын тайлангаа хувийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлээгүй байна.....	6
10. Дүгнэлт.....	6
11. Зөвлөмж.....	7
12. Тэмдэглэл.....	8

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНСДИТХСТ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай
ГАА	Говь-Алтай аймаг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НА	Нийцлийн аудит
ШТА	Шууд тайлагнах аудит



1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

АНСДИТХС-ийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг¹-ийг үндэслэн Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж баталгаажууллаа.

2. Аудитын зорилт

Говь-Алтай аймаг, сумдын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлын тайланг хянаж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд оршино.

3. Аудитын хамарсан хүрээ

Говь-Алтай аймгийн Бугат, Эрдэнэ сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн аудитын дүгнэлт, дэлгэрэнгүй тайлан, маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамарсан.

4. Аудитад ашигласан арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS: 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт” Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны А/15 дугаар “Аймгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нэг нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмээг тогтоох тухай”, А/16 дугаар “Сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нэг нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмээг тогтоох тухай” тушаалыг тус тус үндэслэн нам, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив, түүний зарцуулалтын тайланг шалгаж, ирүүлсэн баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйлд цуглуулж тайланг бэлтгэв.

5. Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

¹ 57.1. Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.



Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг хэрэгжүүлж, аудитор Ц.Сайханжаргал төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэн, аудитын гүйцэтгэлийн болон дүгнэлт боловсруулах үе шатны ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрүүдэд гүйцэтгэж үе шатны хяналт хийлгэн, 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр олон нийтэд Төрийн аудитын байгууллагын цахим хуудсаар мэдээлж ажиллалаа.

Үндсэн мэдээлэл

Сонгуулийн ерөнхий хорооны 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дугаар “Цаг хугацааны хуваарь батлах тухай” тогтоолын хавсралтаар аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарийг баталжээ.

АНСДИТХС-ийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэгт “Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгуулийг жил бүрийн 6 дугаар сарын гурав дахь долоо хоногийн Ням гарагт улс даяар нэгдсэн журмаар явуулна.” гэж заасны дагуу Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийг 2025 оны 06 сарын 22-ны өдөр зохион байгуулсан.

Говь-Алтай аймагт Бугат, Эрдэнэ сумдад тус бүр 1 мандатад нөхөн сонгуулийн явуулсан. Монгол ардын нам, Ардчилсан намаас сонгуульд оролцохоо илэрхийлэн Бугат сумын Сонгуулийн хорооны 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолоор 2 нэр дэвшигчийг, Эрдэнэ сумын Сонгуулийн хорооны 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолоор 2 нэр дэвшигчийг, нийт 4 нэр дэвшигчийг бүртгэсэн байна.



Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 3 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа хувийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлээгүй.

- 1.1. АНСДИТХС-ийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэг²-т заасны дагуу нөхөн сонгуульд оролцсон 4 нэр дэвшигч сонгуулийн зардлын харилцах дансаа бүртгүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- 1.2. Бугат сумын Ардчилсан намаас нэр дэвшигч нэг иргэн хараат бус аудитын хуулийн этгээдээр сонгуулийн зардлын тайландаа аудит хийлгэн ирүүлжээ.
- 1.3. Эрдэнэ сумын Ардчилсан намын хорооны 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 03 дугаар албан бичгээр нэр дэвшигч нь сонгуулийн зардлын харилцах данс нээлгээгүй тухай ирүүлсэн.
- 1.4. Гэтэл Хаан банкны Говь-Алтай салбарын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 144 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн дансны хуулгаар Эрдэнэ сумын Ардчилсан намаас нэр дэвшигч нь өөрийн хувийн харилцах дансаар сонгуулийн хандивын гүйлгээ хийсэн байж болзошгүй байна.
- 1.5. Бугат сумын Монгол ардын намаас нэр дэвшигч, Эрдэнэ сумын Монгол Ардын намаас нэр дэвшигч нар сонгуулийн зардлын харилцах данс нээлгэсэн боловч АНСДИТХС-ийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т хэсэг³-т заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа хувийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан Төрийн аудитын газарт ирүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- 1.6. АНСДИТХС-ийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэг⁴-т заасны дагуу Хаан банк нь 2 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны гүйлгээний хуулгыг 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 144 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлжээ.



- 1.7. Төрийн банк нь 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 41/501 дугаар албан бичгээр 2 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны гүйлгээний хуулгыг ирүүлсэн бөгөөд хуульд заасан хугацаанд үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- 1.8. Сонгуулийн зардлын дансаа хувийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн 1 нэр дэвшигч орлогын болон зарлагын гүйлгээ хийгээгүй байна.
- 1.9. Бугат сумын нөхөн сонгуульд оролцсон 2 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансаараа орлогын болон зарлагын гүйлгээ хийгээгүй байна.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 2 нам сонгуулийн зардлын тайлангаа хувийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлээгүй байна.

- 2.1. Аймгийн сонгуулийн хорооны 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дугаар албан бичгээр нөхөн сонгуульд Бугат, Эрдэнэ сумын Монгол ардын нам, Ардчилсан намууд оролцсон байна.
- 2.2. Тус намуудаас АНСДИТХС-ийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасны дагуу зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан Төрийн аудитын байгууллагад ирүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Дүгнэлт

Говь-Алтай аймгийн Бугат, Эрдэнэ сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигч, намын сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нэгтгэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Нөхөн сонгуульд оролцсон 2 нам, 4 нэр дэвшигч данс бүртгүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй байна. (Хавсралт №1)
- Бугат, Эрдэнэ сумын Монгол Ардын нам, Ардчилсан намууд сонгуулийн зардлын дансандаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, Төрийн аудитын байгууллага ирүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй байна.



- Нөхөн сонгуульд нэр дэвшсэн 3 нэр дэвшигч зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын байгууллагад ирүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй байна. (Хавсралт №2)
- Эрдэнэ сумын Ардчилсан намаас нэр дэвшигч хувийн харилцах дансаар сонгуулийн хандивын гүйлгээ хийсэн байж болзошгүй байна.

Зөвлөмж

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Говь-Алтай аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст

- Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.25-т “Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.8.6.22-т “нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн ...17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил;”-ийг шалган шийдвэрлэнэ гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй нам, нэр дэвшигчид хуульд заасны дагуу арга хэмжээ авах.

Говь-Алтай аймгийн Татварын газарт

- Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.21-т “Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”, 17.1.22-т “Хуульд заасан хэмжээнээс хэтрүүлж нам, эвсэлд, эсхүл нэр дэвшигчид хандив өгсөн, эсхүл тухайн намын нэгдэн орсон эвсэлд давхардуулан хандив өгсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх



хэмжээний төгрөгөөр торгоно”. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.8.6.12-т “татварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн ...17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил;”-ийг шалган шийдвэрлэнэ гэж заасны дагуу сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан үүргээ биелүүлээгүй нам, нэр дэвшигчид хуульд заасны дагуу арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Тэмдэглэл

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Хавсралт №1

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдээс сонгуулийн зардлын дансыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт бүртгүүлээгүй нэр дэвшигчдийн жагсаалт

№	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог, нэр	Нэр дэвшсэн аймаг, сум
1	Монгол Ардын нам	А.Бүнчиндагва	Говь-Алтай аймгийн Бугат сум
2	Ардчилсан нам	Г.Бямбачулуун	Говь-Алтай аймгийн Бугат сум
3	Монгол Ардын нам	Д.Наранчимэг	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум
4	Ардчилсан нам	Л.Нармандах	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум

Хавсралт №2

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон зардлын тайлан ирүүлээгүй нэр дэвшигчийн жагсаалт

№	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог, нэр	Нэр дэвшсэн аймаг, сум
1	Монгол Ардын нам	А.Бүнчиндагва	Говь-Алтай аймгийн Бугат сум
2	Монгол Ардын нам	Д.Наранчимэг	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум
3	Ардчилсан нам	Л.Нармандах	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум